

ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын мэдээллийн хуудас 2018 оны 12 дугаар сарын дугаар

Тэргүүн Мэдээ

Ерөнхий сайд У.Хүрэлсүх ЖАЙКА-ийн Ерөнхийлөгч Ш.Китаокаг хүлээн авч уулзав.



Япон Улсад албан ёсны айлчлал хийсэн Ерөнхий сайд У.Хүрэлсүх 12 дугаар сарын 13-ны өдөр ЖАЙКА-ийн Ерөнхийлөгч Шиничи Китаокаг Токио хотноо хүлээн авч уулзав. Уулзалтын эхэнд Ерөнхий сайд У.Хүрэлсүх Монгол дахь ЖАЙКА-ийн хамтын ажиллагаанд талархал илэрхийлж, улмаар Монголын эдийн засгийн байдал болон ЖАЙКА-ийн хамтын ажиллагааны цаашдын чиглэлийн талаар санал солилцов. ЖАЙКА-нь Монгол Улсад засаглалыг бэхжүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх, нийгмийн суурь үйлчилгээг сайжруулах зэрэг олон чиглэлээр хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэхээр төлөвлөж байгаа юм.

Төслийн хэрэгжилт

Монгол Улсын хот байгуулалтын салбар дахь хамтын ажиллагааны талаарх семинарыг зохион байгуулав.



ТХА-ны “Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх чадавхийг сайжруулах төсөл” хэрэгжиж дуусах гэж буйтай холбогдуулан ЖАЙКА, БХБЯ, НЗДТГ хамтран 12 дугаар сарын 6-ны өдөр Монгол Улсын хотын хот байгуулалтын салбар дахь хамтын ажиллагааг нэгтгэн дүгнэсэн семинарыг зохион байгуулав. Семинарт 100 орчим хүн оролцож, арав гаруй жилийн хугацаанд хэрэгжиж ирсэн ЖАЙКА-ийн хамтын ажиллагааны үр дүнг дүгнэхийн зэрэгцээ нийслэл Улаанбаатар хотын тогтвортой хөгжлийг хангахад төлөвлөгөөнд мониторинг хийх, хотыг дахин хөгжүүлэх төсөлтэй уялдсан орон сууцны бодлого боловсруулах, мэргэжилтэн бэлтгэх зэрэг үйл ажиллагаа чухал ач холбогдолтой болох талаар санал бодлоо хуваалцав.

Эмнэлгийн мэргэжилтний харилцаа, хандлага ёс зүйн сургалтын хөтөлбөр боловсруулав.



ТХА-ны “Анхан ба хоёр дахь шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл” дээр 11 дүгээр сараас эхлэн ЖАЙКА-ийн дадлагажигч Нанамацу Юү эмнэлгийн мэргэжилтний харилцаа, хандлага, ёс зүйн сургалтын багцыг боловсруулахад голлон ажилласан ба 12 дугаар сарын дундуур туршилтын сургалтыг зохион байгууллаа. Нанамацу дадлагажигч нь эмч, өвчтөн болон эмнэлгийн мэргэжилтнүүдийн дунд харилцаа болон ёс зүйн талаар анкет судалгаа явуулах замаар тулгамдаж буй асуудлуудыг тодруулан, ЭМЯ ба Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хороотой хамтран сургалтын багцыг боловсруулсан байна. Эмнэлгийн тусламж, үйлчилгээг сайжруулахад чухлаар тавигдаж буй асуудлын нэг болох харилцаа ёс зүйг сайжруулахад энэхүү сургалтын багц хөтөлбөрийг ашиглахаар төлөвлөж байна.

“Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг бэхжүүлэх төслийн III шат” хэрэгжиж эхлэв.



12 дугаар сарын 12-ны өдөр ТХА “Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг бэхжүүлэх төслийн III шат”-ны Хамтарсан Зохицуулах Хорооны анхдугаар хурал болж, төсөл албан ёсоор хэрэгжиж эхлэв. Агаарын бохирдол нь Улаанбаатар хотын тулгамдсан асуудлын нэг бөгөөд уг хуралд Нийслэлийн Агаарын Бохирдлыг Бууруулах Газар болон холбогдох байгууллагын төлөөлөл оролцож төслийн үйл ажиллагаа, агуулгын талаар идэвхтэй санал солилцов. 4 жил хагас орчим хугацаанд хэрэгжих энэхүү төсөл нь Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах бодитой арга хэмжээнд чиглэсэн үйл ажиллагааг явуулахын зэргэцээ байгууллагууд хоорондын уялдаа холбоог зохицуулах тогтолцоог сайжруулахад онцгой ач холбогдол өгч ажиллах юм.

ЖАЙКА ба Татварын Ерөнхий Газрын хамтын ажиллагааны 20 жилийн ой тохиов.



2018 онд ЖАЙКА болон ТЕГ-ын хамтын ажиллагаа хэрэгжиж эхэлсний 20 жилийн ой тохиож байна. 12 дугаар сарын 5-ны өдөр энэхүү хамтын ажиллагааны 20 жилийн ойд зориулсан хүндэтгэлийн арга хэмжээ ТЕГ-т болж, ТЕГ-аас урт хугацаанд ЖАЙКА-ийн оруулсан хувь нэмрийг үнэлэн талархлын бичиг гардуулав. ЖАЙКА-нь 1998 онд хэрэгжүүлсэн “Монгол улсын зах зээлийн эдийн засгийн шилжилтийг дэмжих судалгаа”-аас эхлэн одоо хэрэгжүүлж буй ТХА-ны “Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь төслийн 2-р шат” хүртэл өргөн хүрээтэй хамтын ажиллагааг үе шаттай хэрэгжүүлж байгаа бөгөөд дотоодод зохион байгуулсан сургалтад Монгол улсын татварын нийт байцаагчдын тоотой дүйцэхүйц 2000 гаруй байцаагчийг хамруулсан байна. ЖАЙКА-нь цаашид ч Монгол Улсын татварын салбарын хөгжилд хувь нэмрээ оруулж хамтран ажиллах болно.

Монгол Япон төвийн бизнесийн харилцааг дэмжих ажлууд амжилттай хэрэгжиж байна.



11 дүгээр сарын 30-ны өдөр МУИС, БСШУСЯ-ны холбогдох төлөөллийн оролцоотойгоор Монгол Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн Хамтарсан Зохицуулах Хорооны 2-р хуралдаан болов. Хурлаар тус төвийн 2018 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэхийн сацуу бизнесийн харилцааг дэмжих ажлууд амжилттай хэрэгжиж буй талаар (бизнес зөвлөгөө авах зорилгоор тус төвөөр үйлчлүүлсэн аж ахуйн нэгжийн тоо өмнөх жилээс 4 дахин нэмэгдсэн) болон аж ахуйн нэгжийн засаглалын судалгаа, Япон Улсад асрагчийн чиглэлээр ажиллах дадлагажигч нарт зориулсан япон хэлний сургалт зэргийг захиалгаар хийж гүйцэтгэсэнээр төвийн орлого нэмэгдсэнийг онцлон тэмдэглэв. Монгол Япон төв нь цаашид ч дээрх үйл ажиллагааг идэвхтэй үргэлжлүүлэхээр төлөвлөж байна.

12 дугаар сарын 3-ны өдөр бол Олон улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдөр : DPUB ба START төслийн үйл ажиллагааны танилцуулга



12 дугаар сарын 3-ны өдөр бол Олон улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөр юм. ТХА “Улаанбаатар хот дахь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл” (DPUB)-ийн хүрээнд энэхүү өдөр Өвөрхангай аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чуулга уулзалт дээр Япон улсын зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээг танилцуулахын хамт хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай (DET) сургалтыг зохион байгуулав. Мөн ТХА “Тусгай хэрэгцээт боловсролын орчныг сайжруулах төсөл (START)”-ийн хүрээнд Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын өнөөгийн байдлыг харуулсан видео сурталчилгаа (1), (2) хийсэн байна. ЖАЙКА нь цаашид ч хөгжлийн бэрхшээлтэй иргэд ба хүүхдийн амьдрах орчин нөхцлийг сайжруулахад дэмжлэг үзүүлж ажиллана.

Сайн дурын үйл ажиллагааны танилцуулга (Наранцэцэг багштай ярилцах уулзалт)



11 дүгээр сарын 6-ны өдөр ЖАЙКА-гийн сайн дурын гишүүд оролцсон “Наранцэцэг багштай ярилцах уулзалт” ЖАЙКА-гийн Монгол дахь Төлөөлөгчийн газар болон Нихон Мацу хотод байрлах сайн дурын гишүүдийн сургалтын төвийг холбосон онлайн хэлбэрээр зохион байгуулагдав. Наранцэцэг багш сайн дурын гишүүдэд 25 гаруй жилийн турш Монгол хэл зааж, Монгол Японыг холбосон гүүр болон ажиллаж ирсэн билээ. Тус уулзалтын үеэр Наранцэцэг багш социализмын үед Япон Улстай холбогдох болсон шалтгаан зэрэг өөрийн туулсан бодит амьдралаар дамжуулан Монгол Япон хоёр орны харилцаа хэрхэн өөрчлөгдөж ирсэн тухай, Монгол дахь сайн дурын гишүүдийн үйл ажиллагааны талаар санал бодлоо хуваалцсан бөгөөд хоёр орны хөгжлийг өөр өнцгөөр харах боломжийг олгосон сонирхолтой арга хэмжээ болов.



ЖАЙКА-ийн Сургалт төгсөгчдийн холбоо

Японы олон улсын татвар ногдуулалтын туршлагыг танилцуулах семинар болов.



ЖАЙКА-ийн “Олон улсын татвар ногдуулалт” сургалтанд оролцогч 12 дугаар сарын 7-ны өдөр Японы олон улсын татвар ногдуулалтын туршлагыг танилцуулах семинар зохион байгууллаа. 2018 оны санхүүгийн жилд зохион байгуулах Follow Up семинарын сонгон шалгаруулалтанд тэнцсэн энэхүү семинарт Улаанбаатар хотын татварын хэлтсүүдийн 90 гаруй байцаагч оролцсон бөгөөд Японы туршлага дээр үндэслэн олон улсын татвар ногдуулалтын талаар ойлголт өгч, Монголд нэвтрүүлэх боломжийн талаар санал хэлэлцүүлэг явууллаа.

事務所ナショナルスタッフが日本語で執筆！

コラム ～モンゴルの文化・生活事情紹介～ 「モンゴルでもボルシチ」

ロシアの伝統料理で日本でも知られている「ボルシチ」は、モンゴルで一般的な家庭料理として親しまれています。皆さんご存知ですか？体温まる野菜たっぷりのボルシチは、モンゴルの寒い冬にぴったりな一品です。牛肉、ビーツ、キャベツ、玉ねぎなどバターで炒めた後、煮込み、サワークリームをのせれば完成。ビーツの鮮やかな深紅茶色の煮込みスープを皆さんもぜひ一度お試しください！（ソロンゴ所員）

※写真は我が家の手作りボルシチです。



Бие даасан захиргааны хуулийн этгээд Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны

Байгууллага(ЖАЙКА) –ын Монгол дахь Төлөөлөгчийн газар.

Бодь цамхаг, 7 давхар, Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар, Монгол улс

(Төв шуудан, шуудангийн хайрцаг: 682, Улаанбаатар 211213, Монгол улс)

Утас:+976-325939, 311329, Факс:+976-310845 Имэйл: mg_oso_rep@jica.go.jp